# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 03 өдөр　　　　Дугаар А/18　　　　Цагаан-Овоо

Луус сумын Сумын орон нутгийн хөгжлийн
сангийн хөрөнгөөр''Мал угаалгын банн''
хийж гүйцэтгэх ажлын тендерийн гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлаас санхүүжүүлэх “Мал угаалгын банн хийж гүйцэтгэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Ж.Уянга(Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн) |
| Гишүүд: | Н.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч) |
| | Ц.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга) |
| | Ө.Бадамцэцэг (Луус сумын цэцэрлэгийн туслах багш) |
| Нарийн бичгийн дарга: | С.Пагамсүрэн (Иргэний төлөөлөл) |

2.Үнэлгээний хорооны тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Уянга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (С.Пагамсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА　　　　Б.ӨЛЗИЙХИШИГ

4823010035